# МОНГОЛ УЛС
# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/134 Мөрөн сум

Урамшуулал олгох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр гүйцэтгэл 80 буюу түүнээс дээш хувиар үнэлэгдсэн сумдын Засаг дарга нарт цалингийн хувиар нэг удаа урамшуулах жагсаалтыг хавсралтаар батлагсугай.

2.Сумын Засаг дарга нарт олгох цалингийн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс тооцож олгохыг байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нямжав)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010409

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 29-ний өдрийн А/134 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

# 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭРЭЭР 80 ХУВЬ БУЮУ ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИАР ҮНЭЛЭГДСЭН СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ НЭГ УДАА ОЛГОХ ЦАЛИНГИЙН УРАМШУУЛАЛ

| Д/д | Сумын нэр | Үйл ажиллагааны үнэлгээгээр үнэлэгдсэн хувь | Олгосон урамшуулал /төгрөгөөр/ | |
|---|---|---|---|---|
| 1 | Тариалан | 84.33% | Үндсэн цалингийн 30% | Тухайн сумын ЗДТГ-ын төсвөөс олгоно. |
| 2 | Төмөрбулаг | 84.31% | | |
| 3 | Ханх | 84.23% | | |
| 4 | Мөрөн | 83.72% | | |
| 5 | Их-Уул | 83.32% | | |
| 6 | Цэцэрлэг | 83.06% | | |
| 7 | Баянзүрх | 83.05% | | |
| 8 | Эрдэнэбулган | 82.61% | | |
| 9 | Хатгал | 80.56% | | |
| 10 | Шинэ-Идэр | 80.14% | | |

________ оОо________